

ДАРХАН УУЛ АЙМГИЙН  
ДАРХАН СУМЫН 30 ДУГААР ЦЭЦЭРЛЭГ



# “ЧИЙРЭГ ХҮҮХЭД” ТӨСӨЛ

2025 он

30-р цэцэрлэгийн гадна талбайг тоглоомжуулах  
төслийн танилцуулга

2025.12.31

Төслийн нэр:	“Хүүхдийн хөгжлийн төлөө хамтдаа”
Төслийн бүтэц	Цэцэрлэгийн гадна талбайг, зүлэгжүүлэх, моджуулах, хашаажуулах, тоглоомжуулах
Хөтөлбөр хэрэгжүүлэгчийн байршил	Дархан сум 4-р баг 22-р хороолол 30 дугаар цэцэрлэг /хуучин прокурорын байр/
Төсөл санаачлагч	30-р цэцэрлэгийн багш, ажилчид хамт олон
Төслийн үр шим хүртэгч	30-р цэцэрлэгийн хүүхдүүд болон 4-р багийн иргэд хүүхдүүд
Төслийн санхүүжүүлэгч	Дархан –Уул аймгийн ЗДТГ, “Ногоон Дархан-2032” хөтөлбөр
Төслийн нийт төсөв	12.195.000 төгрөг
Төсөл хэрэгжүүлэх хугацаа	2026 оны 1-р улиралд

Холбогдох ажилтан: Эрхлэгч Х.Отгонтуяа

Хаяг байршил, утас : Дархан сум IV баг, өөрийн байр

77097076, 99394802, 88001041

Facebook хаяг: Дархан Гучдугаар цэцэрлэг

## ЦЭЦЭРЛЭГИЙН ТАНИЛЦУУЛГА

1. Цэцэрлэгийн дугаар: 30 дугаар цэцэрлэг
2. Цэцэрлэгийн байршил: Дархан сум 4-р багийн нутаг дэвсгэр
3. Хамран сургах тойрог: Дархан сум 4, 5-р багийн нэмэлтээр  
гэр хорооллын Малчин багийн хүүхдүүд
4. Хүмүүжүүлж буй хүүхдийн тоо: 265 хүүхэд
5. Багш ажиллагсдын тоо : 32 багш, ажилтан

Дархан сумын 30-р цэцэрлэг нь анх 1982 оны 4-р сарын 20-нд байгуулагдан “Орос” цэцэрлэг нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж байгаад 1992 онд татан буугдсан түүхтэй. Олон жил ашиглагдаагүй гадны нөлөөллөөр тоногдсон барилгыг Дархан уул аймгийн Засаг захиргаа ОХУ-ын Хилийн чанад дахь өмчийг удирдах үйлдвэрийн газартай гэрээ байгуулан түрээслэн авч 2020 онд их засвар хийгдэн ашиглалтад орж 2020 оны 09 дүгээр сарын 31-нд үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд одоогийн байдлаар 265 хүүхэд хамрагдан суралцаж байна.

### БИДНИЙ УРИА:

***“Хайраар үлгэрлэе, Хамтдаа хөгжье”***

### АЛСЫН ХАРАА

Хүүхэд бүр аз жаргалтай суралцан хүмүүжин хөгждөг МАНЛАЙЛАГЧ ЦЭЦЭРЛЭГ болно.

### ЭРХЭМ ЗОРИЛГО

Үлгэрийн олон талт арга зүйгээр хүүхдэд зөв үнэт зүйлийг төлөвшүүлнэ.

### Төслийн тодорхойлолт:

Цэцэрлэгийн гадна тоглоомын талбай нь хүүхдийн хөгжлийг дэмжсэн тоглоом хэрэглэгдэхүүн, ногоон байгууламж дутмаг байгаа нь СӨБ-ын байгууллагын орчны стандарт шаардлагыг хангахгүй байгаа тул энэхүү төслийг хэрэгжүүлэх шаардлагатай байна. Төсөл хэрэгжсэнээр хүүхдийн сургалтын болон тоглох орчин бүрдэх бөгөөд ялангуяа хүүхдийг тоглонгоо суралцах, гадаа талбайд чөлөөтэй тоглох, идэвхтэй хөдөлгөөнийг дэмжих, хүүхэд гүйх, авирах, мөлхөх үсрэх зэрэг үндсэн хөдөлгөөний чадварыг эзэмшихэд чухал нөлөө үзүүлэх эрүүл аюулгүй орчин бүрдэнэ.

### Төслийн үндэслэл:

Цэцэрлэгийн гадна тоглоомын талбай нь хүүхдийн хөгжил, сонирхол, хэрэгцээг дэмжсэн тоглоом хэрэглэгдэхүүн, ногоон байгууламж дутмаг байгаа тул энэхүү орчинг сайжруулах бололцоог хангахыг эрмэлзэж байна.

Гадна тоглоомын талбай тохижуулснаар хүүхдийн идэвхтэй хөдөлгөөнийг дэмжсэн суурин болон аюулгүй байдлыг хангасан тоглоомтой болох, нар, ус, агаараар чийрэгжүүлэх орчинг бүрдүүлэн ногоон эко орчин бүрдүүлэх, хүүхдийн аюулгүй байдлыг хангасан талбайг бий болгох.

### Төслийн зорилго:

Бага насны хүүхдийн нас сэтгэхүйн хөгжлийн онцлогт тохирсон тэдний бие бялдар хөдөлгөөний хөгжлийн хэрэгцээг хангах, идэвхтэй хөдөлгөөнийг дэмжсэн зориулалт бүхий комплекс тоглоом хэрэглэгдэхүүнээр тохижуулах, нар ус агаараар чийрэгжүүлэх тоглоомоор эрүүл аюулгүй орчныг бүрдүүлж ажиллах зорилготой.

### Гарах үр дүн:

Цэцэрлэгийн гадна талбайд бага насны хүүхдийн тоглож наадах, агаар салхинд бие бялдын хөдөлгөөнийг дэмжих чийрэгжих аюулгүй, эко орчин бүрдэнэ.

## ТӨСЛИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТООЦОО

№	Хэрэглэгдэхүүний нэр	Тоо ширхэг нэгж	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Ногоон байгууламжийг хашаажуулах	ш	239500	2.395.000
2	Гацуур мод	15ш	250.000	3.750.000
3	Ногоон зүлэг /хар шороо, үр, элс/	кг	3.000.000	3.000.000
4	Гадна талбайг тэгштгэх элс, хайраг, тоосго, хар шороо	10тн	80.000	800.000
5	Гоёлын мод	15	150.000	2.250.000
Нийт дүн			12.195.000 төгрөг	

“ДОМОГТ ШАРЫН ГОЛ” ХХК

ЗУРАГ -1



**“ТАРИМАЛ УРГАМАЛ” ХХК “ЗҮЛЭГЖҮҮЛЭЛТ, ХАШААЖУУЛАЛТ  
ЗУРАГ – 2**



**“ЗҮЛЭГЖҮҮЛЭХ ТАЛБAYН ӨМНӨХ”**

**ЗУРАГ – 3**

